



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 334

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дугаар заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.8, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эзэмшлийн нийслэлийн Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороонд байрлах орон сууцны зориулалттай 2054 м.кв талбай бүхий газрын зориулалтыг "орон сууц, контор, үйлчилгээний" болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал С.Энхцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Зориулалт өөрчлөгдөж байгаатай холбогдуулан газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээ, бусад холбогдох баримтыг шинэчилж, шаардлагатай тохиолдолд санхүүгийн тайланд бүртгэлтэй эрхийн үнэлгээнд өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу боловсруулан саналаа ирүүлэн шийдвэрлүүлэх;

2.2.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

00067